

ПЛИТОНИТ СУПЕРКАМИН ХАЛУУНШАВАРДЛАГА

Үсгийн утга:

Халуун Өнгөлгөөний шавардлага

Нэршил:

Зуух, камин зуух, яндангийн халуунд тэсвэртэй цагаан өнгөлгөөний шавардлага

Тэмдэглэгээ:



+400°C, РПО

ОРОСЫН ЗУУХНЫ ХОЛБОО

Давуу тал:

- ☐ Гадна болон дотор талын ажилд зориулсан
- ☐ Будгийн дор болон өнгөлгөөний бүрхүүл болгон ашиглах
- ☐ Тэгшлэх давхаргын зузаан нь 2-30 мм байна
- ☐ Бэхжүүлэгч утсаар батжуулсан
- ☐ Өнгө - цагаан
- ☐ Тоосгоны хэлтэрснийг дүүргэхэд ашиглаж болно
- ☐ Бүтэцтэй засвар хийх боломжтой

Өнгө

цагаан

Энэхүү хольц нь дотоод засалд зуух, камин зуух болон бусад халсан гадаргууг вааран болон шамот тоосгоор өнгөлгөө шавардлага хийх мөн зуух, камин, яндангийн гадна ханыг тэгшлэх, төгсгөлийн засвар хийхэд зориулагдсан. Өнгөлгөөний шавардлага нь зуух, камин зууханд гадаад үзэмжтэй байдал өгдөг бөгөөд цаашдын будалт эсвэл гоёл чимэглэлийн бүрээсэн засал, түүний дотор вааран хавтангаар бүрэхэд ашиглаж болно. Хольцыг ашиглан шавардлагын өмнө том хагарал, тэгш бус гадаргууг дүүргэн засах боломжтой. Шавардлага ашиглах нь зуух, задгай зууханд дулаан хадгалах системийг сайжруулдаг. Энэ нь өндөр технологийн шинж чанартай, түүнчлэн хагаралд тэсвэртэй, материалын зарцуулалт багатай. Савлагаа — 25 кг.

Бүтээгдэхүүний зарцуулалт

1 мм зузаантай түрхэх үед 1 кг/м²

Ажлын нөхцөл

Ажлын явц болон гүйцэтгэлээс хойших 3 хоногт агаарын температур болон тоосгыг +5°C хэмээс +30°C хэмийн хооронд байх нь зохимжтой. Ажлын явцад зуурмагийн хольцын температур, +10 °C хэмээс +30°C хэм хүртэл байх нь зохимжтой.

Суурийг бэлтгэх

Зуух бүрэн хатаж, суулт болсны дараа л шавардлагын ажлыг гүйцэтгэдэг. Өнгөлгөөний доорх гадаргуу нь бат бэх байх шаардлагатай, ажил эхлэхээс өмнө гадаргууг тоос, шороо, тос, бүх төрлийн будаг болон цавуу, хуурах боломжтой элементүүдээс сайтар цэвэрлэх шаардлагатай. Зууханд шавардлага хийхийн өмнө галлаж халаахыг зөвлөж байна. Шавардлага хийхийн өмнө бэлтгэсэн суурийг Плитонит Грунт хөрсжүүлэгчээр боловсруулж, 1 цагийн турш хатаана.

Зуурмаг бэлтгэх

Зуурмагийг бэлтгэхийн тулд энгийн ундны усыг ашиглана. Холих харьцаа нь 1 кг хуурай өрлөгийн хольцод 1 кг-д 0,18-0,22 литр (25 кг-д 4,5 - 5,5 литр) ус шаардагдах байна. Хуурай хольцыг тасалгааны температурт урьдчилан хэмжин авсан ус уруу хийнэ, нэгэн төрлийн жигд болтол нь 2-3 минутын турш эргэлтийн хурд нь 600 эргэлт/мин-ээс ихгүй байх цахилгаан холигч эсвэл цахилгаан өрмийн тусламжтайгаар холино. Зуурмагийг ойролцоогоор 10 минут амраан дахин холино. Энэ үед зөвшөөрөгдсөн хамгийн дээд хэмжээний үлдсэн усыг нэмж хэрэглэж болно. Бэлэн болсон зуурмагийн хольцыг хэрэглэх хугацаа 4 цагаас илүүгүй байна.

Ажлын дараалал

Зуурмаг болон металл бүтээгдэхүүн хоёрын хооронд хүрэлцэхээс зайлсхий. Шаардлагатай бол эхний давхаргыг бүрэн хатаасны дараа хоёр дахь давхаргыг түрхэнэ. Хатах хугацаа нь давхаргын зузаан, суурийн температур, хүрээлэн буй орчны нөхцөл байдлаас хамаарна. Шавардлага хийх үед залгаасыг бататгах шаардлагагүй. Хэлбэр гаргагч хусуур ашиглан та гоёл чимэглэлийн бүтэц хийж болно. Тусгай халуунд тэсвэртэй будаг ашиглан өнгөлгөөний шавардлагыг будаж болно. Шавардлагын ажил дууссаны дараа бүтцийг өөрөөр нь хатаана. 7 хоногийн дараа гаднах гадаргуугийн температур + 50°C хэмээс хэтрэхгүй тохиолдолд уг байгууламжийг ашиглалтад оруулж болно. 10-14 хоногийн дараа бүрэн ажиллагаа явуулах боломжтой.

Аюулгүй ажиллагаа

Хольц нь ОХУ-ын стандарт хэмжилзүйн газрын ГОСТ 12.1.007 стандартын дагуу аюулын 4-р (бага аюултай бодис) ангилалд хамаарна. Ажил гүйцэтгэхдээ бээлий, нүдний шил, амны хаалт хэрэглээрэй. Зуурмагийг арьс, нүдэнд хүрэхээс зайлсхийх. Нүдэнд хүргэсэн тохиолдолд нэн даруй их хэмжээний усаар зайлна. ХҮҮХДЭЭС ХОЛ БАЙЛГА!

Анхааруулга

Ажил гүйцэтгэхдээ барилгын норм ба дүрэм 41-01-2003 шаардлагыг дагаж мөрдөх шаардлагатай. Дээр заагдсан шинж чанарууд нь орчны температур (20+2±60+10)°C, агаарын харьцангуй чийгшил (60±10)%-д үйлчилнэ. Ажлыг гүйцэтгэхдээ барилгын ерөнхий ажил гүйцэтгэх зааварчилга, барилга угсралтын ажилд мөрдөгдөх аюулгүй ажиллагааны зааварчилга дагаж мөрдөх ёстой. Ажил гүйцэтгэх явцад зуурмагийг үе үе хольж байх ёстой. Бэлэн зуурмаг дээр нэмж ус хийхийг хориглоно. Ажил гүйцэтгэхдээ бээлий өмсөөрэй.

Тээвэрлэлт болон хадгалах нөхцөл

Хуурай хольцыг ачаа тээвэрлэх дүрмийн дагуу бүрхүүлтэй тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Хуурай хольцтой уутыг савлагааны аюулгүй байдал, чийгээс хамгаалсан хаалттай хуурай өрөөнд хадгална. Үйлдвэрлэгчийн саванд хадгалах хугацаа нь тээвэрлэх, хадгалах нөхцөл зөрчигдөөгүй үед үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар байна.

Орц, найрлага

Нийлмэл эрдэс бодисын зууралдагч, ширхэгтэй элс, эрдэс бодисын дүүргэгчүүд, хувиргах полимер нэмэлтүүд

Үйлдвэрлэгчийн баталгаа

Хэрэглэгч тээвэрлэх, хадгалах нөхцөл, энэхүү гарын авлагад заасан зааврыг дагаж мөрдсөн тохиолдолд хольц нь техникийн үзүүлэлтүүдийн шаардлагад нийцэж байгааг үйлдвэрлэгч баталгаажуулна. Үйлдвэрлэгч нь материалтай ажиллах технологийг дагаж мөрдөхгүй байх, түүнчлэн эдгээр зааварт заагаагүй зорилго, нөхцөлд ашиглах үед хариуцлага хүлээхгүй. ГОСТ Р 8.579-2001 стандартын дагуу цэвэр жингийн хазайлт байна. Бүтээгдэхүүнийг бүх төрлийн иргэний барилгад ашиглахыг зөвшөөрсөн. (Аэфф<370 Бк/кг байх ОХУ-ын Цацрагийн аюулгүй байдлын стандартууд НРБ-99/2009, ариун цэврийн дүрэм, журам СанПиН 2.6.1.2523-09 нийцсэн).

Техник үзүүлэлтүүд

Хамгийн том дүүргэгч ширхгийн хэмжээ	0,63 мм
1 кг хольцод хэрэглэх усны хэмжээ 25 кг хольцод	0,18 - 0,22 л 4,5 – 5,5 л
1 мм-ийн зузаантай давхаргаар түрхэх үед зарцуулалт	1 кг/м ²
Ашиглалтын үеийн хамгийн их температур	+400°C
1 удаа түрхэх ашиглалтын хамгийн их зузаан	2-15 мм
Түрхэх хамгийн их зузаан	30 мм
Түрхэх хамгийн их зузаан хэсэгчлэн тэгшлэх үед	50 мм
2 дахь давхаргыг	12-24 цагийн дараа түрхэнэ
Зуурмагийн шахалтад байлгахад бат бэх	3,5 МПа-аас багагүй
Зуурмагийн үлдэгдэл тунгалаг чанар	2,0 МПа-аас багагүй
Зуурмагийн хүйтэнд тэсвэртэй байдлын марк	F50 багагүй
Бэлэн болсон зуурмагийн хольцыг хэрэглэх хугацаа	4 цагаас багагүй

Чухал зөвлөмжүүд

Зуухыг өөрийн гараар хэрхэн яаж хийх талаарх зөвлөмжийг удахгүй манай superkamin.ru шинэ вэб сайтаас олж аваарай. Зуух, пийшингийн төслүүдийг энд цуглуулж үзүүлсэн байгаа. Зуухны өрөх дарааллыг өрлөгийн эгнээ тус бүрээр үзүүлэв. Зуухны мастеруудын нарийвчилсан зааварчилга, мэргэжлийн зургийг ашиглан та өөрөө зуух барих боломжтой юм. PLITONIT СуперКамин цувралын бүтээгдэхүүний тусламжтайгаар та камин зуух, шорлогийн зуух, сауны зуух, Швед зуух, тогоонд зориулсан зуух болон бусад төрлийн зуух хийх боломжтой.

Шавардлагыг шамот тоосгоор тавих, засах бол PLITONIT СуперКамин ОгнеУпор ашиглана. Зуух, камин зуухны өнгөлгөөний хувьд халуунд тэсвэртэй хавтангийн цавуу PLITONIT СуперКамин ТермоКлей ашиглана.

Шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний арга боловсруулалтын хэлтсийн эрхлэгч _____ Туршилт, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга _____ 25.12.2020 3 хуудасны 3 дүгээр